

БАТЛАВ.

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН
ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ БАРИЛГЫН НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

ATA12937 9116621 9024070582

2024 оны ...-р сарын ... -ны өдөр


Дугаар № 2024/01-12

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль- Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаал.
2	Хөрөнгө оруулагч	<ul style="list-style-type: none">- Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none">- Эдийн засаг, хөгжлийн яам- Боловсролын яам
4	Барилга байгууламжийн байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none">- Тухайн хот, суурин газрын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөх.
5	Барилга байгууламжийн зориулалт, ангилал	<ul style="list-style-type: none">- Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын жишиг хичээлийн байр- Дунд төвөгшилтэй барилга байгууламж
6	Барилга байгууламжийн хэмжээ, давхрын тоо	Барилга байгууламжийн хэмжээ, давхрын тоо "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" /БНБД 22-01-21*/22/, "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНБД 31-25-22/ барилгын норм ба дүрмийн шаардлагаар төлөвлөх.
7	Барилгажих талбайн эзлэх хувь	"Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт" /БНБД 30-01-04/, "Олон нийт иргэний барилга" /БНБД 11-03-03/ барилгын норм ба дүрмийн дагуу төлөвлөх.
8	Ерөнхий төлөвлөгөө, гадна тохижилтын ажилд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">- Эдэлбэр газрын хэмжээг нэг хүүхдэд ногдох талбай холбогдох норм, дүрмийн дагуу тооцож төлөвлөх;- Ерөнхий төлөвлөгөөг сурагчдын насны онцлогт нийцүүлж хуваасан орон зай, тусгай бүс бүрд үүрэг зориулалт, төлөвлөлтийн шаардлагыг тусгасан, хүрээлэн буй суурьшлын нутаг дэвсгэртэй харилцан холбож төлөвлөнө.- Биеийн тамир спортын талбай, амралтын буюу тоглоомын талбай, хогийн сав, авто зогсоол, сургалт туршилтыг талбай, багш ажилчдад зориулсан авто зогсоол, эцэг эхчүүдэд зориулсан түр зогсоол, дугуйн зогсоол, ногоон байгууламж төлөвлөнө.

		<ul style="list-style-type: none"> - Биеийн тамирын талбай нь олон улсын стандартын шаардлага хангасан хэмжээ бүхий резин эсвэл хатуу хучилттай, хөл бөмбөгийн талбайд зүлэг байхаар төлөвлөх; - Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах; - Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх; - Хур тунадасны ус зайлуулах системийг төлөвлөж өгөх; - Амралтын бүс ногоон байгууламжтай, аж ахуйн болон биеийн тамирын талбайгаас зайтай төлөвлөх; - Хог цуглуулах талбай руу орох орц бие даасан, хүрэх зам нь хатуу хучилттай, хог цуглуулах талбай нь хаалт бүхий тусгаарлагчтай байх; - Эдэлбэр газрын талбайн 50%-иас багагүй талбай нь ногоон байгууламж байна. - Сургуулийн эдэлбэр газар нь 1,5 м-ээс багагүй өндөртэй ногоон байгууламж эсвэл хашаагаар хүрээлэгдсэн байх; - МБТБ-ын сургуулийн барилгаас тухайн сургуульд хамааралтай авто зогсоол хүртэлх зайг 25м, тээврийн хэрэгслийн зогсоолыг 25-аас багагүй байхаар тооцож төлөвлөх; - Эдэлбэр газрын талбайн гэрэлтүүлгийг холбогдох нормын дагуу төлөвлөх; - Авто зам тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарц, гамшгийн үеийн цугларах аюулгүй талбайг холбогдох норм дүрэм, стандартын дагуу төлөвлөх; - Барилгын орчны байгууламж руу хүрэх явган хүний зам хатуу хучилттай байхаар төлөвлөх; - “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт” /БНБД 30-01-04/, “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт” /БНБД 31-25-22/, “Барилгын орчны тохижилтын ажил” /БНБД 3.01.06-90/, “Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 35-01-22/ барилгын норм ба дүрмийн шаардлагад нийцсэн байх.
9	Барилга байгууламжийн гал тэсвэршлийн анги	Гал тэсвэршлийн анги II
10	Барилга байгууламжийн ашиглалтын хугацаа	50 жил
11	Барилга байгууламжийн хариуцлагын зэрэг,	Хариуцлагын 2-р зэрэглэлийн буюу өндөржүүлсэн чухал.


	хариуцлагын зэргийн илтгэлцүүр	Хариуцлагын найдваршлын илтгэлцүүр 1.1-р авна.
12	Барилга байгууламжийн даацын үндсэн бүтээцийн төрөл, материал	Төмөр бетон каркас Төмөр бетон каркасын бетон анги: B20 Арматурын анги: A240, A400 (ГОСТ 34028-2016)
13	Барилгын гадна фасад	<ul style="list-style-type: none"> - Барилгын гадна фасадыг байгаль цаг уурын нөхцөлд тохирохуйц (Говь, Хангайн бүсэд) 2-оос доошгүй хувилбараар төлөвлөх. - Метал хавтан эсхүл орчин үеийн дэвшилтэд технологийн шийдэлтэй байх.
14	Инженер геологийн судалгааны талаарх шаардлага	Барилгын буурийг овоолтгүй, суултгүй энгийн хөрс байхаар тооцож, тооцооны эсэргүүцэл: R=250кПа байхаар тооцно.
15	Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт	Гадна агаарын тооцооны температур: 3 хувилбараар төлөвлөх (-30C ⁰ , -35C ⁰ , -40C ⁰). Цасны ачаалал: 50 кг/м ² Салхины ачаалал: 23 кг/м ²
16	Инженерийн шугам, сүлжээнд тавигдах шаардлага	Инженерийн хангамжийн оролтыг 2-оос доошгүй хувилбараар төлөвлөх ба халаалтын системийг гадна агаарын -30C ⁰ , -35C ⁰ , -40C ⁰ температурт тус тус тооцох шаардлагатай.
17	Барилгын талбайн газар хөдлөлтийн тооцооны эрчим	Газар хөдлөлтийн 6, 7, 8, 9 баллын эрчимд 4 хувилбараар боловсруулах.
18	Архитектур төлөвлөлтийн шаардлага	<p>Барилгад төлөвлөх өрөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хичээлийн танхим, 6ш /Шаардлага тус бүрд нийцүүлсэн байх/ - Дадлагын танхим, 4ш /МБТБ-ын сургуулийн сургалтын чиг үүрэгт зориулж танхимын зохион байгуулалтыг өөрчлөх боломжтой байхаар төлөвлөх/ - Хичээлийн хэрэгслийн агуулахууд - Ариун цэврийн өрөө /Эрэгтэй, эмэгтэй суралцагч болон багш ажилчдын/ - Үндсэн дадлагын танхим /МБТБ-ын сургуулийн сургалтын чиг үүрэгт зориулж танхимын зохион байгуулалтыг өөрчлөх боломжтой байхаар төлөвлөх, овор хийц ихтэй үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой байхаар заалыг өндөр таазтай, 4-6м өндөр төмөр хаалгатай, хувцас солих өрөөтэй төлөвлөх/ - Удирдлагын өрөө /Захирал, эрхлэгч/ - Багш нарын өрөө - Гал тогоо /Хоол үйлдвэрлэлийн хэсгийг технологи урсгалын дагуу агуулах, хувцас солих өрөө, бэлтгэлийн өрөө, гал тогоо, хооллох заалны хамт төлөвлөх/ - Санхүү, аж ахуйн өрөө - Эмчийн өрөө /Тусгаарлах өрөөний хамт/




		<ul style="list-style-type: none">- Номын сан /Уншлагын танхим, ном хадгалах фонд өрөөний хамт/- Техник хэрэгслийн өрөө /техникийн ажилчны өрөөний хамт/ <p>Төлөвлөлтийн шаардлага</p> <ul style="list-style-type: none">- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ерөнхий шаардлага /MNS 6541:2015/ стандартын шаардлага хангасан барилга байгууламж төлөвлөх- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг “Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 35-01-22/ барилгын норм ба дүрмийн дагуу төлөвлөх.- Үндсэн үүрэг зориулалтын өрөө тасалгааны байрлал, чиглэлийг нарны шууд тусгалыг нормчлогдсон хугацаагаар тооцох ба “Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын /эзвэрлэлтийн/ хангамж” /БНБД 23-04-07/ барилгын норм ба дүрмийн шаардлагын дагуу төлөвлөх.- Зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу ус, дулаан, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй материал түүхий эд, технологийг тухайн орон нутгийн онцлог, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг оновчтой сонголттойгоор тусгах.- Ачаа зөөх лифт төлөвлөх- Барилгын үндсэн хийц бүтээц болон хашлага бүтээц, гадна, дотор засалд хэрэглэх материал нь хүүхдийн эрүүл ахуйн шаардлага хангасан байх.- Барилгын шал халтирдаггүй материалтай, хөтөч замтай төлөвлөгдөх.- Сурагчдын хичээлийн танхим модон эсвэл шинэ технологи ашиглана.- Орчны аюулгүй байдлыг хангасан олон нийтийн хэсэгт цилиндр багана, хурц өнцөг үүсгэхгүй багана болон хананы булангийн ирмэгийг дарж төлөвлөх.- Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах.- Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх.- Хур борооны ус барилга болон зам талбайд сөрөг нөлөөгүй байх.
--	--	--



19	Зургийн үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"> - Нэг үе шаттай - Ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу байна.
20	Зураг төслийн бүрдэл	<ol style="list-style-type: none"> 1. Загвар зураг 2. Ажлын зураг төсөл <ul style="list-style-type: none"> - Ерөнхий төлөвлөгөө ЕТ - Барилга архитектур БА - Барилга бүтээц ББ /Барилга бүтээцийн тооцооны тайлан/ - Халаалт, агаар сэлгэлт ХАС /Барилгын эрчим хүчний гэрчилгээ/ - Цэвэр, бохир ус ЦБУ - Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг ХТ,ДГ - Холбоо дохиолол ХД - Автоматик АУ - Төсөв /магадлал хийсэн ажлын зураг төслийн дагуу төсвийг программаар гүйцэтгэсэн байх/ 3. Мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, зөвлөмж <p>Ажил гүйцэтгэх аргачлал:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу боловсруулж, магадлал хийлгэсэн ажлын зураг, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь 1 хувь, хуулбар 3 хувь хэвлэмлээр, файл /autocad, pdf, төсөв зохиосон программын өргөтгөлтэй/ хэлбэрээр CD-нд бичиж 1 хувь хүлээлгэн өгнө.
21	Зураг төсөл боловсруулахад дагаж мөрдөх норматив баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"> - Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зураг төсөв боловсруулах. - Барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон загвар зураг боловсруулж барилгын асуудал хариуцсан болон захиалагч байгууллагаар хянуулж, зөвшилцөх. - Зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу ус, дулаан, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй материал түүхий эд, технологийг тухайн орон нутгийн онцлог, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг оновчтой сонголттойгоор тусгах. - Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах.



		<ul style="list-style-type: none"> - Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх. - Хур борооны ус барилга болон зам талбайд сөрөг нөлөөгүй байх.
22	Зураг төсөл боловсруулахад дагаж мөрдөх норматив баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"> - Заавал мөрдөх норм дүрмүүд - “Барилга бүтээцийн тооцооны тайлан, түүний бүрдэлд тавих шаардлага” /БД 11-123-20/ - “Барилгын загвар /эталон/ зураг” хэрэглэх заавар - “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” MNS 6055:2009 - “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” MNS 6782:2019 - “Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6444:2014 - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөсөн заавар” MNS 6056:2009
23	Галын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт - Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт - “Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал” /БНБД 21-01-02/ - “Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” /БНБД 21-02-02/ - “Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” /БНБД 21-04-05*/18/ гэх мэт холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу орц, гарц, аваарын хаалга, шат болон барилга дотор галын гидрант, гал унтраах шланг тавих хайрцаг, галын дохиолол зэргийг төлөвлөнө.
24	Онцгой нөхцөл	<ol style="list-style-type: none"> 1. Барилгын эзлэхүүнт төлөвлөлтийн бүтэц нь ашиглахад ая тухтай таатай нөхцөлтэй уялдуулан холбож төлөвлөх; 2. Эрүүл ахуйн тухай хуулийн 1.4, 4.2, 3.4, 4.4 дэх заалт ба “Олон нийт, иргэний барилга” /БНБД 31-03-03/*11/ сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийн 2.4, 2.6, 2.7, 2.8, 2.15 дах заалт Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагын 7.2, 7.4 дэх заалтын дагуу шаардлагыг төлөвлөлтөд заавал тусгах; 3. Хүүхдийг цонх, шат, довжоо зэргээс унахаас сэргийлсэн аюулгүй байдлыг тооцож тоноглогдсон байх;



	<p>4. Барилгын сууринд ирэх хүчлэлүүдийг тодорхойлж суурийн зурагт хүснэгтээр тусгаж өгөх.</p> <p>5. Газар хөдлөлтийн 6, 7, 8, 9 болон аймаг орон нутгийн цаг уурын байдлыг бүсчлэн тооцоолох;</p> <p>6. Өдрийн турш хүүхэд байгалийн гэрэл, агаар солилцоог бүрэн авч байх нөхцөлийг нарийн тооцоолох;</p> <p>7. Хичээлийн танхим, урлаг, спортын заалны шалыг зориулалтын модон шалтай байхаар зураг төсөлд тусгах;</p> <p>8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага, өндөр настан, бага насны хүүхдийн биеэ авч явах нөхцөл байдалд нийцүүлэх;</p> <p>9. Төлөвлөлтийн норм нормативын баримт бичгийн шаардлагад заасны дагуу тэмдэг тэмдэглэгээг төлөвлөх;</p> <p>10. Барилгад хэрэглэх материал хүүхдийн эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байх;</p> <p>11. Хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөл боломжийг бүрэн тусгасан байх;</p> <p>12. Барилгын гадна фасадын материал, өнгийг тухайн орон нутагт нийцүүлэх боломжтой байх;</p> <p>13. Барилгын төлөвлөлт, гадна хэв загвар, өнгө төрх нь хүүхдийн сонирхлыг татахуйц орчин үеийн шийдэлтэй байх;</p> <p>14. Урлаг, спортын заалыг тусад нь төлөвлөх ба дасгал, хөдөлгөөн хийхэд бүрэн боломжтой модон шал төлөвлөсөн байх;</p> <p>15. Хоол үйлдвэрлэлийн хэсэгт хүнсний түүхий эдийг гаднаас тусдаа хаалгаар оруулахаар төлөвлөх;</p> <p>16. Хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах үүднээс камержуулалтыг холбогдох нормын дагуу гадна, дотор төлөвлөх;</p> <p>17. Эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй "Барилгын дулаан хамгаалалт" /БНБД 25-01-20/ барилгын норм, дүрмийг хангах;</p> <p>18. Сэргээгдэх эрчим хүчийг тусгах;</p> <p>19. Хөдөлгөөнөөр гэрэлтүүлэх төхөөрөмжөөр тоноглох, эрчим хүч хэмнэсэн гэрэлтүүлэг ашиглан ерөө тасалгааг гэрэлтүүлэх систем хэрэглэх;</p> <p>20. Эрчим хүчний хэмнэлттэй буюу ашигт үйлийн итгэлцүүрийг дээшлүүлэх нэрийн жагсаалттай уялдуулан үр ашигтай инженерийн тоног төхөөрөмжийг хэрэглэх;</p> <p>21. Дулааны эрчим хүчний ангилал нь В буюу В+ байх;</p> <p>22. Барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 150/A271/A225 дугаар тушаалаар батлагдсан журам мөрдөх;</p>
--	--



		23. Засгийн газрын 2023 оны “Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” 322 дугаар тогтоолын хэрэгжилт хангаж, шүд угаах булан төлөвлөх;
25	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
26	Зөвшилцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> - Эдийн засаг, хөгжлийн яам - Боловсролын яам - Эрүүл ахуй, галын аюулгүй байдлын асуудал хариуцсан төв байгууллага - Холбогдох мэргэжлийн байгууллага

ХЯНАСАН:

Боловсролын яамны Санхүү, Хөрөнгө оруулалтын газрын дарга



Б.Батцэцэг

Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга



Х.Тамираа

Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч



Ч.Батболд


БОЛОВСРУУЛСАН:

Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн



Б.Түмэнбаяр

Боловсролын яамны барилгын инженер



Л.Лхагвадалай

_____ооо_____